

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТТАЙ БАЙНА

Даланзадгад 2017

АГУУЛГА

Аудитыг гүйцэтгэсэн: Дарга, тэргүүлэх аудитор П.Алтанзаяа Аудитын менежер Д.Алдармөнх Ахлах аудитор Т.Хонгорзул Аудитор Д.Сүрэнжаргал Ш.Отгонбаяр Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Нутгийн удирдлагын ордон 303 тоот Даланзадгад сум Өмнөговь аймаг	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл.....3-4 Товчилсон үгийн жагсаалт5 Бүлэг А. - Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах төлөвлөгөө боловсруулж ажилласан байна.....7 - Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж боловсруулсан байна.....7 - Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудыг олон нийтээр хэлэлцүүлсэн байна.....8 - Хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилт хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцоололыг тусгасан байна.....8 - Орон нутагт хамааралгүй байна.....9 - Аймгийн Засаг дарга хөгжлийн бодлогын баримт бичигт санал авах, боловсруулах үүргээ хэрэгжүүлж байна.....10 Бүлэг Б. - Орон нутагт хамаарахгүй.....11 - Хяналт-шинжилгээ үнэлгээг хуулиар тодорхойлсон хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.....11 - Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, дүгнэх мэдээлэх үүрэг бүхий албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.....12 Бүлэг В. - Батлагдсан хөгжлийн бодлогын бичиг баримтыг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулж байна.....13 - Аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагууд хөгжлийн бодлогын уяалдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих арга зүй, удирдлагаар хангаж ажиллаж байна.....14 Дүгнэлт:15 Холбогдох байгууллагын санал Тайлан баталгаажуулсан тушаал
--	---

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт

	Хавсралтууд: Судалгаа 1 Судалгаа 2 Судалгаа 3
--	---

АУДИТЫГ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ

Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх үүрэг хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн эсэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Хөгжлийн бодлого баримт бичгийг хууль, тогтоомж, журамд нийцүүлэн төлөвлөж, боловсруулсан эсэх
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль, журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж байгаа эсэх

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ

Аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөгдөж эхэлсэн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш боловсруулж батлан, хэрэгжүүлж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тамгын газрыг хамруулан шалгалаа.

АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглан дүн шинжилгээ хийж нэгтгэн аудитын дүнг боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж өглөө.

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР:

Дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль;

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт

- Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”;
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам;

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар

Бүлэг А

Хөгжлийн бодлогын баримт
бичгийг хууль журмын дагуу
төлөвлөж боловсруулсан байна.

А.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах төлөвлөгөө боловсруулж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн а/576 захирамжаар Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулсан байна.

Аймгийн хэмжээнд мөрдөгдөж байгаа 17 дэд хөтөлбөрийг боловсруулах ажлын төлөвлөгөөнд зохион байгуулах арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, зохион байгуулалтыг хангах ажлын хэсгийн гишүүн, хэрэгжүүлэх байгууллага албан тушаалтан бүрийг тодорхой тусгаж өгчээ. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2¹ дэх заалт, Засгийн газрын 249 дүгээр тогтоолын 13,17² дэх заалтуудыг хэрэгжүүлэн ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө боловсруулж ажилласан байна.

А.2 Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж боловсруулсан байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нөхцөл байдлын дүн шинжилгээг АЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хийсэн байна. Нөхцөл байдлын дүн шинжилгээнд дараах асуудлыг тусгажээ.

- Хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх асуудлууд,
- Бодлогын баримт бичиг боловсруулах асуудлууд,
- Бодлогын хувилбар боловсруулах асуудлууд,
- Бүтээн байгуулалтын асуудлууд,
- Бусдын санаачлагыг дэмжих, хамтран ажиллах
- Хяналтын удирдлага, тогтолцоог сайжруулах асуудлууд
- Цахимжуулах, онлайн горимд шилжүүлэх асуудлууд
- Аймгийн хэлтэс, агентлагуудад хамаарах заалтууд
- Сумдад хамаарах заалтууд

¹15.2 Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

² 13.Засаг дарга нь дараах төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлаг, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаач, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан байгуулж, удирдамжаар ханган үйл ажиллагаанд нь хяналт тавина.

13.1 аймаг нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт

13.2 дэд хөтөлбөр

17.13-т заасан ажлын хэсэг нь төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.

Хөтөлбөрийг боловсруулахдаа нөхцөл байдлын дүн шинжилгээг хийн бодлогын баримт бичгийн уялдаа холбоог боловсруулан Засгийн газрын 249 дүгээр журмын 20, 21, 23³ дэх заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

А.3 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудыг олон нийтээр хэлэлцүүлсэн байна.

Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг АЗДТГ-ын хэлтэс тасгууд хариуцан гүйцэтгэж, үнэлгээний дүгнэлтийг төсөлд тусгасан байна. Тухайлбал: “Англи хэлтэй-Өмнөговь” хөтөлбөр хэрэгжсэнээр хүүхэд залуучуудын англи хэлний хэлний мэдлэг чадвар дээшилж, сурах хүсэл сонирхол, идэвх нэмэгдэнэ. Даяаршлын эрин зуунд дэлхийн иргэний нэг байхад нөлөөлөх хамгийн гол түлхүүр болох англи хэлийг эзэмшсэнээр бүх салбарт хөгжих гарц илүү нэмэгдэх юм байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа төрийн болон төрийн бус байгууллага, сум, баг, аж ахуйн нэгж, иргэн бүрийн саналыг тусгах ажлыг бүх шатанд олон хэлбэрээр зохион байгуулж, 13 салбар хэлэлцүүлгийг хийж, 3500 гаруй иргэнийг хамруулан 3000 гаруй санал гарсаныг журмын дагуу нэгтгэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрүүдэд тусгасан байна.

Дэд хөтөлбөрийг боловсруулахдаа нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийн, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1⁴, Засгийн газрын 249 дүгээр журмын 31.4⁵ заасны дагуу хүснэгт маягтаар боловсруулан олон нийтээр хэлэлцүүлсэн байна.

А.4 Хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилт хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгасан байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэн 2016, 2017 онуудад 15 дэд хөтөлбөрийг боловсруулан жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Дээрх дэд хөтөлбөрүүдэд боловсруулах үндэслэл, хэрэгжих нөхцөл байдал, зорилго, зорилт, зарчим, санхүүжилт, хэрэгжих хугацаа, хүрэх үр дүн, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, хүлээх үүрэг, хяналт шинжилгээ, үр дүн шалгуур үзүүлэлтийг тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал: Элэг бүтэн-Өмнөговьчууд хөтөлбөрт

³ 20.Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхдээ тухайн бодлогын баримт бичигт тусган шийдвэрлэх эдийн засаг,нийгэм, эсхүл тодорхой зорилтот бүлэгт урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх хүндрэл, бэрхшээлийг мэдэрч, асуудлыг тодорхойлно.

21.Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх ажилд тухайн асуудлаас хамааруулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ,судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, холбогдох бусад талуудыг оролцуулна.

23.Нөхцөл байдлын шинжилгээ нь тухайн асуудлаар хөгжлийн бодлогын баримт бичиг боловруулах үндэслэл,шаардлагыг гаргасан тулгамдсан асуудлыг мэдэрч тодорхойлсон баримт бичиг байна.

⁴ ...аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын баримт бичгийн төслийг нийтлэх, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, хэлэлцүүлэх, санал авах үйл ажиллагааг холбогдох төв төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага зохион байгуулна.

⁵ 31.4 энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан төслийг нийтээр хэлэлцүүлсэн хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудыг багцалсан товъёог

Зорилго: Өмнөговь аймгийн ард иргэдийн дундах элэгний ВС вирусын халдвар, элэгний бусад эмгэгийг эрт илрүүлж, эмчлэн эрүүлжүүлэх замаар элэгний шалтгаант өвчлөл, эндэгдэлийг бууруулах.

Зорилт: 1.18-аас дээш насны иргэдийн 80-аас доошгүй хувийг элэгний эмгэгийн эрт илрүүлэгт хамруулах.

2.Элэгний эмгэгийн эрт илрүүлэлтээр элэгний эмгэгийн өөрчлөлт бүхий иргэдийн 90-ээс доошгүй хувийг хяналтанд авч, эмчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн: Элэгний өвчлөлд хүргэж байгаа эрсдэлт зан үйлийг бууруулах мэдээлэл, сургалт, сурталчилгаа, судалгааг хийж, дархлаажуулалтын хамралтын хувийг нэмэгдүүлж, судалгаа, нотолгоо бий болсон байна.

Хяналт шинжилгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт: Хөтөлбөрийн хэрэгжилтийг тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжих бөгөөд хэрэгжилтийг жил бүрийн 12 сард гаргах ба төгсгөлийн үнэлгээг шалгуурын дагуу 2020 оны 4-р сард гаргана. Явцын үнэлгээг хагас, бүтэн жилээр гаргах бөгөөд АЗДТГ, ЭМГазраас тусгай үнэлгээний шалгуураар үнэлж тухай бүр нь зөвлөмжөөр хангаж, хэрэгжилтийг дүгнэж ажиллана. Дэд хөтөлбөрийг дараах эс үүсвэрээс санхүүжүүлэхээр тусгажээ. Үүнд:

- Орон нутгийн төсөв,
- Төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хандив,
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хандив тусламж,
- Бусад санхүүгийн эх үүсвэрээс

Хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилт хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцоололыг бодитой тусган Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17.1, 17.2⁶ дэх заалт, Засгийн газрын 249 дүгээр тогтоолын 52⁷ дэх заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

А.5 Орон нутагт хамааралгүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3⁸, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн

⁶ 17.1 Хөгжлийн бодлогын баримт бичгийг доор дурдсан дарааллын дагуу боловсруулна

17.1.1 хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, тугамдаж байгаа асуудал,бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох

17.1.2 асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн бодлогын хувилбарыг боловсруулах

⁷ 52. Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн тухай хуулийн 6.3, 6.4.3-т заасан төсөл дараах ерөнхий бүтэц агуулгатай байна.

52.1 Ерөнхий мэдээлэл

52.2 Бодлогын зорилго, зорилт

52.3Бодлогыг хэрэгжүүлэх үе шат үйл ажиллагаа

52.4 Бодлогын үр нөлөө, бүтээгдхүүн, шалгуур үзүүлэлт

52.5 Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр

52.6 Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

⁸ Энэ хуулийн 10.2-т заасан жагсаалтад орсон үндэсний хөтөлбөрийг төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд боловсруулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна.

бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 31⁹-д заасан үндэсний хөтөлбөр, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг аймгийн хэмжээнд боловсруулахгүй тул орон нутагт хамаарахгүй заалт болно.

А.6 Аймгийн Засаг дарга хөгжлийн бодлогын баримт бичигт санал авах, боловсруулах үүргээ хэрэгжүүлж байна.

Аймгийг 2010–2020 онд хөгжүүлэх “Байгалийн баялаг–Сайн засаглал–Хөгжсөн Өмнөговь” хэтийн зорилт нь 2009 онд батлагдсан тул энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй байна. Аймгийн ИТХ-ын 2016 оны 2/2 тогтоолоор Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 17 дэд хөтөлбөрийн жагсаалтыг баталсан байна. Засаг дарга Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 13-т заасны дагуу аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2016 оны а/576 дугаар захирамжаар байгуулж, өргөн цар хүрээтэй, нийгмийн бодлогын чухал ач холбогдолтой 8 дэд хөтөлбөр боловсруулах салбар ажлын хэсгийг томилж хууль журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

⁹ Төрийн захиргааны төв байгууллага нь төрөөс баримтлах бодлогын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авна.

Бүлэг Б

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хууль журмын дагуу тайлагнаж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Б.1 Орон нутагт хамаарахгүй.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 8 дугаар зүйлийн 8.6, 9 дүгээр зүйлийн 9.4, 10 дугаар зүйлийн 10.7, Улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1 дэх хэсэг орон нутагт хамаарахгүй заалт болно.

Б.2 Хяналт-шинжилгээ үнэлгээг хуулиар тодорхойлсон хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1¹⁰-д заасны дагуу Өмнөговь аймгийн 2010-2020 онд бүсчлэн хөгжүүлэх “Байгалийн баялаг-Сайн засаглал хөгжсөн Өмнөговь” хөтөлбөрийг АИТХ-ын 2009 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 5/11 дугаар тогтоолоор баталсан байна.

АЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6¹¹-д заасны дагуу хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн, хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ хийж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулсан байна. Уг тайлан дүгнэлт, зөвлөмжийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хуралд танилцуулан, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэхэд бэлтгэсэн байна.

Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.7¹²-д заасны дагуу аймгийг 2013-2016 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хяналт-шинжилгээ хийж дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ 93,2 хувьтай хэрэгжсэн гэж дүгнэсэн байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцохдоо зорилт тус бүрээр, хариуцсан нэгж, албан тушаалтнаар ангилан гаргаж хэрэгжилтийн мэдээллийг нэгтгэн, тооцоо судалгаа хийж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд цаашид анхаарах асуудлаар арга зүйн зөвлөгөө, зөвлөмжийг боловсруулж ажилласан байна.

Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах нийтлэг журам”-ын 24¹³-д заасны дагуу шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичигт нөлөөллийн үнэлгээ хийх ажлыг 2017 оноос эхлүүлж аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2018 оны төслийг боловсруулахад хэрэгжүүлэн ажиллаж

¹⁰ Засаг дарга тухай шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өгсөн чиглэлийн дагуу аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

¹¹ Нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, ажлыг зохион байгуулж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

¹² Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

¹³ Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг төсөл санаачлан боловсруулж байгаа захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэж, уг үнэлгээний дүгнэлтийг төсөлд тусгасан байна.

байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5¹⁴-д заасны дагуу Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг тооцож эхний хагас жилд 30,0 хувь, сүүлийн хагас жилийн байдлаар 92,8 хувьтай дүгнэсэн байна. Өмнөх онтой харьцуулахад салбар бүрт ахиц дэвшил гарч статистик болон тоо үзүүлэлтүүд өссөн ч цаашид хүрсэн үр дүнгээ баталгаажуулах алдаа дутагдлаа засах зэрэг асуудлыг тусгасан зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

Б.3 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, дүгнэх мэдээлэх үүрэг бүхий албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2¹⁵-д заасны дагуу 2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 2/2 дугаар Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн жагсаалтыг батлуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4 бүлэг, 16 зорилт, 166 заалттай бөгөөд нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд 55, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлээр 64, байгаль орчныг хамгаалах бодлогын хүрээнд 18, орон нутгийн засаглалын бодлогын хүрээнд 29 асуудлыг тусгасан байна.

Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4¹⁶-д заасны дагуу АИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар 2016 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 85,1 хувь хэрэгжсэн гэж дүгнэн, 2017 оны үндсэн чиглэлийг баталжээ. Сумдын ИТХ хуульд заасан хугацаанд сумын үндсэн чиглэлийн хэрэгжилтийг тооцон дүгнэж, ирэх оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх, үндсэн чиглэлээ батлан хуульд нийцүүлэн ажилласан байна.

¹⁴ Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

¹⁵ Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

¹⁶ Тухайн шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ

Бүлэг В

Баримт бичгийг олон нийтэд
мэдээлэх, арга зүй, нэгдсэн
удирдлагаар хангаж ажиллаж байна

В.1 Батлагдсан хөгжлийн бодлогын бичиг баримтыг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулж байна.

АИТХ-аар батлагдсан хөгжлийн бодлогын бичиг баримт бичгийг АЗДТГ-ын олон нийттэй харилцах алба, www.omngovi.gov.mn вэб сайт, олон нийтийн сүлжээ, өдөр тутмын сонин, сэтгүүл боловсруулан иргэдэд тараах, орон нутгийн болон үндэсний хэмжээний телевиз, радиогоор хуулийн 22 дугаар зүйлийн 22.1¹⁷ -д заасны дагуу олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулсан байна.

Иргэдэд хүргэсэн материал

№	Материалын нэр	Агуулга	Тоо хэмжээ
1	Өмнөговь аймгийн 2016-2020 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “БИД ХАМТДАА” хөтөлбөр	Батлагдсан хөтөлбөрийг бүрэн эхээр нь англи, монгол хэлээр бэлтгэж хэвлэсэн танилцуулга гарын авлага	3500 ширхэг
2	Засаг даргын 100 хоногийн мэдээний самбар	Засаг даргын 100 хоногт боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичиг, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг харуулсан самбарыг нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлуулсан байна.	30 ширхэг
3	Монгол говь сонин	Засаг даргын 100 хоногт боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичиг, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг нийтэлсэн Монгол говь сонингийн тусгай дугаар гаргасан байна.	1000 ширхэг
4	Бид Хамтдаа аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан 2016/07-2017/07	Засаг даргын 1 жилийн хугацаанд хийсэн ажлын тайлан, үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд гарсан дэд хөтөлбөр, түүний хэрэгжилтийг оруулсан сэтгүүл	10000 ширхэг

В.2 Аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагууд хөгжлийн бодлогын уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих арга зүй, удирдлагаар хангаж ажиллаж байна.

Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4¹⁸ -т заасны дагуу аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2017 оны 10 дугаар зөвлөмжөөр сумдын хяналт-шинжилгээ, үнэлгээний орон тооны бус ажлын хэсэгт сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлийн

¹⁷ Батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, хэвлэх, сурталчлах ажлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллаг хариуцан зохион байгуулна.

¹⁸ Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт

хэрэгжилтэд үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ хийх, 2018 оны үндсэн чиглэлийн төсөлд нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх чиглэл өгч, арга зүйгээр хангасан байна.

Аймаг, сумдын боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйг хууль, журамд нийцүүлэн аймгийн Засаг даргын 2017 оны а/1163 дугаар захирамжаар баталгаажуулж, тухайн шатны ИТХ-д танилцуулах, дээд шатны байгууллагад тайлан мэдээ хүргүүлэх хугацааг а/1160 дугаар захирамжаар баталгаажуулан холбогдох албан тушаалтныг үүрэгжүүлэн ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах төлөвлөгөө боловсруулж ажилласан байна.
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хууль, журмын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж боловсруулсан байна.
- Хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбаруудыг олон нийтээр хэлэлцүүлсэн байна.
- Хөгжлийн бодлогын баримт бичигт зорилго, зорилт хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцоололыг тусгасан байна.
- Аймгийн Засаг дарга хөгжлийн бодлогын баримт бичигт санал авах, боловсруулах үүргээ хэрэгжүүлж байна.
- Хяналт-шинжилгээ үнэлгээг хуулиар тодорхойлсон хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Батлагдсан хөгжлийн бодлогын бичиг баримтыг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулж байна.
- Аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагууд хөгжлийн бодлогын уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих арга зүй, удирдлагаар хангаж ажиллаж байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.АЛТАНЗАЯА